

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19 MIK HOLDING

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хурлын
21/04 дугаартай тогтоолын Хавсралт №1



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Баримт бичгийн нэр	Компанийн засаглалын кодекс
Хувилбарын дугаар:	1.0
Баримт бичгийн төлөв:	Хүчин төгөлдөр
Хэлэлцэж эцэслэсэн :	2021/03/12 (ОУСК-Ажлын хэсгийн хурал)
Батлагдсан:	2021/03/19 (Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 21/04 дугаартай тогтоол)
Эргэн хянах:	2022/03/20 (ТУЗ-ийн ажлын алба)
Боловсруулсан нэгж:	ТУЗ-ийн ажлын алба
Хяналт тавих:	ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ
Хамаарах компани/нэгж:	Компанийн ТУЗ, түүний дэргэдэх хороод, Гүйцэтгэх удирдлага, бүх газар нэгж

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбарын дугаар	Батлагдсан огноо	Товч утга	Боловсруулсан нэгж
1.0	2021/03/19	ОУСК-ийн зөвлөмжид заасан асуудлаар боловсруулж анхны хувилбарыг хэлэлцэн батлав.	ТУЗ-ийн ажлын алба

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

АГУУЛГА

ЗОРИЛГО

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭС СУУРЬ.....	III
1.1. Тодорхойлолт ба зарчим	III
1.2. Компанийн засаглалын дотоод баримт бичиг.....	III
1.3. Засаглалын ерөнхий бүтэц.....	IV
1.4. Компанийн засаглалын бодлого, хэрэгжилтэд дагаж мөрдөх, хянан нийцүүлэлт	IV
БҮЛЭГ 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ПРАКТИК АЖИЛЛАГАА.....	IV
2.1. Төлөөлөн удирдах зөвлөл	V
2.2. Гүйцэтгэх удирдлага.....	VII
2.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа ба ТУЗАА-ны оролцоо.....	VIII
БҮЛЭГ 3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ.....	VIII
3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал.	VIII
3.2. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах	IX
3.3. Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх ажил, гүйлгээ.	IX
3.4. Ногдол ашгийн бодлого	IX
БҮЛЭГ 4. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ.....	IX
4.1. Компанийн мэдээллийн бодлого ба практик ажиллагаа.....	X
4.2. Санхүүгийн тайлан	X
4.3. Дотоод аудит ба хяналт.....	X
4.4. Хөндлөнгийн аудит	X
4.5. Компанийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, мэдээлэх	X

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

ЗОРИЛГО

Энэхүү Компанийн засаглалын кодекс (цаашид “кодекс” гэх)-ын зорилго нь компанийн засаглалын тогтолцоог сайжруулж бэхжүүлэх, засаглалыг илүү ил тод, нээлттэй болгох, компанийн засаглалын талаарх сайн тууштай байдлаа харуулах явдал юм.

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭС СУУРЬ

1.1. Тодорхойлолт ба зарчим

“Компанийн засаглал”-ыг компанийн удирдлага, хяналтын бүтэц, үйл явц гэж тодорхойлдог. Компанийн сайн засаглал нь компанийн үр ашиг, нэр хүндийг дээшлүүлж, бага зардлаар санхүүжилт татах арга хэрэгсэл гэж үздэг. Түүнчлэн засаглалын тогтолцоо нь улс орны нийгэм, эдийн засагт компанийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.

Энэ засаглалын кодексийг МИК Холдинг ХК, МИК ОССК ХХК, МИК Рийл Эстэйт ХХК, Протего Фест ХХК болон цаашид үүсгэн байгуулагдах охин компаниуд дагаж мөрдөнө.

Компанийн засаглалын практик нь дараах зарчимд суурилна. Үүнд:

- **Шударга хандах:** Компани нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, бүх хувьцаа эзэмшигчид ижил тэгш хандах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй.
- **ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, ГУ-ийн мэргэжлийн үр чадвар, хариуцлага:** ТУЗ, ТУЗ-ийн хороод, Гүйцэтгэх удирдлага нь Хувьцаа эзэмшигч болон компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн үнэнч, шударга, үр бүтээлтэй, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид ажиллаж үр дүнг хувьцаа эзэмшигчдэд тайлагнан ажиллах үүрэгтэй..
- **Компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал:** Компани нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой бизнесийн нууц болон маш нууцад хамаарахаас бусад мэдээллийг цаг тухайд нь өөрийн цахим хуудас болон мэдээллийн бусад бололцоот сувгуудыг ашиглан нийтэд мэдээлдэг байна.
- **Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо:** Компани нь эрсдэл, дотоод хяналт болон дотоод аудитын нэгжтэй байхаас гадна ажиллагсад нь эрсдэлийн болон дотоод хяналтын ажиллагаанд хэрэглэдэг орчин үеийн арга хэрэгсэл, стандартыг мэддэг, тэдгээрийг өөрийн ажилдаа ашиглаж, хэрэглэж чаддаг байна.
- **Компанийн засаглалын практикийг тасралтгүй сайжруулах:** Компани нь засаглалын практик ажиллагааг үндэсний болон олон улсын сайн жишигт тулгуурлан байнгын сайжруулалт хийж ажиллана.

1.2. Компанийн засаглалын дотоод баримт бичиг

Дараах нэгж, үйл ажиллагааг зохицуулсан баримт бичгүүдийг засаглалын баримт бичигт хамааруулна. Үүнд:

- Компанийн дүрэм;
- Компанийн засаглалын кодекс;
- Компанийн ёс зүйн дүрэм;
- Хувьцаа эзэмшигчдийн хурал;
- Төлөөлөн удирдах зөвлөл;
- ТУЗ-ийн дэргэдэх хороод;

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

- ТУЗ-ийн ажлын алба;
- Гүйцэтгэх удирдлага;
- Компанийн хяналтын тогтолцоо;
- Эрсдэлийн удирдлага;
- Комплаенс;
- Дотоод аудит;
- Ногдол ашгийн бодлого;
- Компанийн мэдээллийн бодлого;
- ТУЗ-ийн үнэлгээ.

Дээрх баримт бичгүүд нь Монгол Улсын КтХ, ҮЦЗЗтХ, ХБҮЦтХ, СЗХ-оос баталсан Компанийн засаглалын кодекс болон зохицуулах байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх баримт бичгүүдийн холбогдох зохицуулалтыг баримтлан боловсруулагдсан байхаас гадна компанийн засаглалын чиглэлээр ажилладаг ОУ-ийн болон Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорац зэргээс гаргасан зөвлөмж, баримт бичигт суурилсан болно.

1.3. Засаглалын ерөнхий бүтэц

- **Хувьцаа эзэмшигчдийн хурал** нь компанийн эрх барих дээд байгууллага бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийг компанийн засаглалд оролцох боломжоор хангана.
- **Төлөөлөн удирдах зөвлөл** нь компанийн үйл ажиллагааны стратегийн чиглэлийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг бодлогын чиглэлээр хангаж өгөхүүрэгтэй.
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод** ТУЗ-ийн дэргэд байнгын үйл ажиллагаа бүхий САХ, НДШУХ болон ЭУХ гэсэн байнгын хороодыг заавал байлгах бөгөөд шаардлагатай гэж үзвэл бусад чиглэлээр хороо эсвэл түр хороо байгуулан ажиллаж болно.
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба** нь ТУЗ ба ГҮ-ийн хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог дэмжиж, тэдгээрийг үйл ажиллагаагаа явуулахад нь зөвлөн туслах үүрэг хүлээнэ.
- **Гүйцэтгэх удирдлага** нь Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ТУЗ-өөс боловсруулсан бодлого стратегийг хэрэгжүүлнэ.
- **Дотоод аудитын нэгж** нь Компанийн бизнесийн үйл ажиллагааны процессыг хөндлөнгөөс хянан үнэлж үнэ цэн нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлээр ажиллана. Дотоод аудитор нь ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороогоор дамжуулан ТУЗ-д ажлаа тайлагнах ба захиргааны өдөр тутмын үйл ажиллагааны хувьд Гүйцэтгэх удирдлагын дор ажиллана.
- **Хянан нийцүүлэлтийн нэгж** нь Компанийн Хянан нийцүүлэлтийн үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг боломжит бага түвшинд байлгахтай холбоотой үйл ажиллагааг удирдан зохицуулна.
- **Эрсдэл хариуцсан нэгж** нь Компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч буй болон болзошгүй эрсдэлийг зохистой түвшинд удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэвшүүлж ажиллана.

1.4. Компанийн засаглалын бодлого, хэрэгжилтэд дагаж мөрдөх, хянан нийцүүлэлт

Компани өөрийн засаглалын баримт бичгүүдийг нийтээр дагаж мөрдөж буй хууль тогтоомж, зарчим, кодекс хэрхэн нийцэж буй эсэхийг авч үзэж сайжруулалт хийн ажиллана. Энэ асуудлыг компанийн бүтцэд тусгайлсан нэгж хариуцан гүйцэтгэх бөгөөд энэ нэгж нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх засаглал хариуцсан хороонд тайлагнах үүрэг хүлээнэ.

БҮЛЭГ 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ПРАКТИК АЖИЛЛАГАА

Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэхэд хараат бус мэргэжлийн төлөөлөн удирдах зөвлөл чухал ач холбогдолтой. ТУЗ нь Хувьцаа эзэмшигч, компанийн ашиг сонирхлын төлөө Гүйцэтгэх удирдлагад

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

хяналт тавьж чиглэл өгөх замаар компанийн үйл ажиллагааны үр дүнд нөлөөлнө. Засаглалын бүтцийн эрх мэдэл, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой, ойлгомжтой байдлаар салган заагласан байх нь засаглалыг оновчтой, үр ашигтай болгох суурь үндэс нь болдог.

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл

- 2.1.1. **Эрх мэдэл:** МИК Холдинг ХК-ийн ТУЗ нь МИК ОССК ХХК-ийн ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлдэг. Мөн МИК ОССК ХХК-ийн ТУЗ нь түүний охин компаниудын ХЭХ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн эрх мэдлийн хүрээг холбогдох хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтооно.
- 2.1.2. **ТУЗ-ийн гишүүдийн тоо:** ТУЗ-ийн гишүүний тоог Компанийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлан компанийн дүрмээр тогтооно. Дүрэмд заасан гишүүдийн тоог компанийн тухайн үеийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан өөрчилж болно.
- 2.1.3. **ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, бүрэн эрхийн хугацаа:** ТУЗ-ийн гишүүдийг компанийн дүрэмд заасан хугацаагаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас кумулятив аргаар сонгоно.

ТУЗ-ийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эдийн засаг, эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк санхүү, санхүүгийн менежментийн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, тухайн салбарт таваас доошгүй жил ажилласан;
- Салбартаа гурваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар, эсхүл Гүйцэтгэх удирдлагын багт ажилласан;
- Компанийн засаглалын гэрчилгээ бүхий сургалтад хамрагдсан байх эсвэл хамрагдах боломжтой байх;
- Нэр дэвшихээс өмнө өмчлөх эрх, эдийн засаг, авлига, нийтийн албаны ашиг сонирхол, цахим мэдээллийн аюулгүй байдал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгэл хүлээгээгүй байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь дээрх шаардлагыг хангахыг зэрэгцээ доорх нэмэлт шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
- Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
- Компанийн Гүйцэтгэх удирдлагад ажилладаггүй байхаас гадна Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн гишүүнд нэрийг нь дэвшүүлээгүй байх;
- Компанитай ТУЗ-ийн гишүүнээс өөр бизнесийн аливаа холбоогүй байх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, ялангуяа хараат бус гишүүн нь дээрх шаардлагыг бүрэн эрхийн хугацаандаа ханган ажиллана. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу дахин сонгоно.

- 2.1.4. **ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба хараат бус байдал:** ТУЗ-ийн бүрэлдэхүүний нь нийт хувьцаа эзэмшигчдэд тэгш үйлчлэх шийдвэр гаргах үүднээс ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг гуравны нэгээс (1/3) доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь Компани болон хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхлыг хангах хүрээнд компанийн үйл ажиллагааны стратеги хэтийн чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг хянахад шаардлагатай үр чадвар, мэдлэг, туршлагыг эзэмшсэн хувь хүн байна. ТУЗ-ийн үйл ажиллагаа дахь шударга байдал болон ХЭ бүлгүүдийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангах үүднээс ТУЗ-ийг бүрдүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

- Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн дарга нь Гүйцэтгэх захирлын албан тушаалыг давхар хашихгүй байх;
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд Гүйцэтгэх удирдлагад ажилладаг албан тушаалтны оролцоог аль болох бага байлгах.

Мөн ТУЗ-ийн гишүүдийн эзэмшсэн байвал зохих ур чадвар, мэдлэг туршлагыг ур чадварын матрицаар тодорхойлно. Мөн эрх мэдлийг хуваарилах эрх мэдлийн матрицтай байна. Ур чадварын матриц, эрх мэдлийн матрицыг засаглал хариуцсан хороо боловсруулж холбогдох ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.1.5. ТУЗ-ийн дэргэдэх хороод: Компанийн ТУЗ-ийн дэргэд дараах асуудлыг эрхэлсэн байнгын хороодыг ажиллуулна. Үүнд:

- Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо;
- Санхүү, аудитын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо.

Түр болон бусад чиглэлээр бий болгох хорооны асуудлыг тухай бүр ТУЗ шийдвэрлэнэ. Хороодын үйл ажиллагааг зохицуулах тусдаа дүрэмтэй байх бөгөөд тухайн дүрэмд хороодын эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаагаа явуулах хэлбэр, гишүүдийн эрх, үүрэг зэргийг заавал тусгасан байна. Хороод нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд ТУЗ шийдвэр гаргахад санал, дүгнэлт гаргаж ажиллана. Хороод жил бүр өөрийн ажлыг ТУЗ-өөс баталсан журам, аргачлалын дагуу дүгнэж ТУЗ-ийн хуралд танилцуулан ажлаа тайлагнана.

2.1.6. ТУЗ-ийн үйл ажиллагаа: ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. ТУЗ-ийн хурал нь ээлжит болон ээлжит бус байх бөгөөд жил бүр баталсан хуваарийн дагуу заавал хуралдах хурлыг ээлжит, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн даргын санаачилгаар зарлан хуралдуулах хурлыг ээлжит бус хурал гэж ойлгоно. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн дарга тогтоох ба гишүүдэд мэдэгдэх, хурлын бэлтгэл хангах, хурлын дараах ажиллагаа гэх зэрэг чиг үүргийг ТУЗ-ийн ажлын алба хариуцан хэрэгжүүлнэ. ТУЗ-ийн гишүүн нь тодорхой асуудал хэлэлцүүлэхээр хурлыг хуралдуулах санал гаргах, ТУЗ болон хороодын хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг цаг тухайд авах эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг ТУЗ-ийн ажиллах журамд дэлгэрэнгүй заасан байна. ТУЗ-ийн хараат бус гишүүд жилд 2-оос доошгүй удаа ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар уулзалт зохион байгуулж ярилцлага хийдэг байх ба шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал шийдвэрлүүлэхээр саналаа нэгтгэн ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлж болно. ТУЗ-ийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах үүднээс заавал ТУЗ-ийн даргатай бөгөөд ТУЗ-ийн даргыг хараат бус гишүүн байхыг илүүд үзнэ. Мөн компани ТУЗ-ийн дэд даргатай байж болно. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний даалгаснаар чиг үүргийг ТУЗ-ийн дэд дарга хэрэгжүүлнэ. ТУЗ-ийн үйл ажиллагаа, түүний хурлыг хуралдуулах нарийвчилсан ажиллагааг ТУЗ-өөс баталсан тусгайлсан журмаар зохицуулна.

2.1.7. ТУЗ, түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны үнэлгээ: Үнэлгээ нь ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн дарга болон дэд даргын ажил, ТУЗ-ийн гишүүний ажил, ТУЗ-ийн дэргэдэх хорооны үйл ажиллагаа, хорооны дарга болон гишүүдийн ажил гэсэн үнэлгээний ажиллагаанаас бүрдэнэ. Энэхүү үнэлгээг жил бүр ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ хариуцан хэрэгжүүлж үр дүнг ТУЗ-ийн хуралд танилцуулдаг байна. Үнэлгээг хэрэгжүүлэх тусдаа журам, аргачлалтай байх ба түүнийг ТУЗ-өөс батална.

2.1.8. Залгамж халааны төлөвлөгөө Компанийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой, тасралтгүй явуулах, ТУЗ-ийн гишүүн, чөлөөлөх, түр эзгүй байх, гэнэт өөрчлөгдсөнөөс шалтгаалж хувьцаа хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагч, оролцогч талуудад аливаа байдлаар сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг бэлтгэн төлөвлөнө. Тус залгамж халааны төлөвлөгөөг ТУЗ-ийн дэргэдэх засаглал хариуцсан хороо боловсруулан холбогдох ажлыг хийж гүйцэтгэнэ.

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

- 2.1.9. **ТУЗ-ийн гишүүдийн сургалт:** Компани нь ТУЗ-ийн гишүүд болон шинээр томилогдож буй гишүүдэд компанийн үйл ажиллагаа болон засаглалын баримт бичигтэй танилцуулах, гишүүдийн ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөртэй байна. Сургалтын агуулга, зохион байгуулалтын хөтөлбөрийг ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ гаргах зохион байгуулалтыг ТУЗАА хэрэгжүүлнэ.
- 2.1.10. **ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал:** ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин нь суурь болон нэмэгдэл гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Суурь цалин гэдэг нь ХЭ төлөөлж компанийн удирдах байгууллагад ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаагийн төлөө олгогдох цалинг хэлнэ. Нэмэгдэл цалин гэдэг нь ТУЗ болон өөрийн гишүүнчлэл бүхий хорооны хурлыг удирдсан, оролцон ирц бүрээр тооцох цалинг хэлнэ. ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн урамшуулал олгож болох бөгөөд үнэлгээний журамтай уялдсан байна. ТУЗ-ийн гишүүдэд олгох цалингийн төсөв түүний гүйцэтгэлийн мэдээлэл нь хөрөнгө оруулагч болон олон нийтэд ил тод, нээлттэй байна.
- 2.1.11. **ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага:** ТУЗ-ийн гишүүд нь компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж үнэнч шударгаар, ашиг сонирхлын зөрчил гаргахгүйгээр ажиллах ёстой бөгөөд ийм байдлаар ТУЗ-ийн хурал, өөрийн томилогдсон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал болон ТУЗ-өөс зохион байгуулах бусад үйл ажиллагаанд зохих ёсоор нь идэвхтэй оролцох үүрэгтэй. ТУЗ-ийн гишүүн нь компанитай ижил төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, эсхүл явуулахаар төлөвлөж буй компанийн удирдлагад нэгэн зэрэг ажиллахгүй. Харин бусад төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахдаа ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ. ТУЗ-ийн гишүүд нь компанийн нууц болон маш нууцад хамаарах дотоод мэдээллийг бусдад түгээх, дамжуулах, ашиглуулах, мэдээлэхгүй байхаас гадна өөрийн хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглоно. Мөн компанитай ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй бизнесийн гэрээ хэлцэл байгуулахаас аль болох зайлсхийх ба ийм нөхцөл байдал үүсэх тохиолдолд энэ байдлын талаар ТУЗ-д мэдэгдэж мэдээлж, тус асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохоос татгалзах үүрэгтэй.
- 2.2. **Гүйцэтгэх удирдлага**
- 2.2.1. Компанийн өдөр тутмын болон бизнесийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад компанийн ГУ-ийн хувьд мэргэжлийн болон манлайллын өндөр ур чадвартай байхыг шаардана. Компанийн ГУ-ийг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд Гүйцэтгэх захирал байна.
- 2.2.2. **Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох, чөлөөлөх.** Гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ-оос ирүүлсэн ГУ-д нэр дэвшигчдийг сонгон шалгаруулалтын үр дүн болон ГУ-тай байгуулах гэрээний нөхцөл зэргийг үндэслэн ТУЗ-өөс томилно. ГУ-нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд гэрээнд ГУ-ийн эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл цалин шагнал урамшууллын хэмжээ зэрэг асуудлыг тусгасан байна.
- 2.2.3. **Эрх хэмжээ.** ГУ нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүнтэй байгуулсан гэрээнд заасан эрхийн хүрээнд компанийн зорилго, зорилт болон стратегид тулгуурласан үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 2.2.4. **Гүйцэтгэх удирдлагын ур чадвар.** ГУ нь компанийн үйл ажиллагааг үр ашигтай байлгахад тохирсон дараах мэдлэг, туршлага, мэргэшлийг эзэмшсэн байвал зохино. Үүнд:
- Компанийн хувьцаа эзэмшигч, удирдлагын итгэлийг хүлээж чадсан байх;
 - Нийт хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцэх, үндэслэлтэй шийдвэр гаргах чадвартай байх;
 - Компанид ашиглаж болох шийдэл болон хүмүүсийг удирдан зохион байгуулах арга, туршлагыг эзэмшсэн байх.

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

2.2.5. **Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, гүйцэтгэлийн үнэлгээ.** ГУ-ын цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-өөс тогтоож түүнтэй байгуулах гэрээнд нь заасан байна. Гүйцэтгэх удирдлагын цалин нь тогтмол байна. Харин түүний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн урамшуулал олгож болно. Цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийг тодорхойлох үзүүлэлтийн талаар саналыг зэргийг ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ боловсруулж ТУЗ батална. Гүйцэтгэх удирдлагын ажлыг түүнтэй байгуулсан гэрээнд заасан үзүүлэлтээр жилд 1 удаа ТУЗ-ийн дэргэдэх НДШУХ дүгнэж үр дүн болон саналаа боловсруулан ТУЗ-ийн хуралд танилцуулна.

2.2.6. **Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага.** ГУ нь Компани болон түүний нийт хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлын төлөө үнэнч шударга, нягт нямбай, зохих хууль тогтоомжийг мөрдөж ажиллана. ГУ нь компанитай ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй үйлдлээс зайлсхийх ёстой. Ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд үүссэн ашиг сонирхлын зөрчлийн талаар ТУЗ-д мэдэгдэж, асуудлыг ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ. ГУ нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид хохирол учруулбал эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх ба учруулсан хохирлыг нөхөн төлнө.

2.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа ба ТУЗАА-ны оролцоо.

Компанийн сайн засаглал нь ТУЗ болон ГУ хооронд ажил хэрэгч, шууд харилцаа бий болгох нөхцөл бүрдэхэд нөлөөлнө. ГУ нь өөрийн гүйцэтгэсэн ажлын болон компанийн үйл ажиллагааны талаарх тайланг хууль тогтоомж болон бусад баримт бичгээр тогтоосон хугацаанд гаргаж ТУЗ-д тайлагнаж байх ёстой. Мөн ТУЗ шаардлагатай тохиолдолд тодорхой чиг үүрэг бүхий удирдах түвшний зарим албан тушаалтнуудтай шууд харьцах боломжтой байна. Энэхүү харилцаанд ТУЗ-ийн ажлын алба зуучлах, мэдээлэл солилцох арга замыг хөнгөвчлөх үүднээс оролцоно. ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ-өөс томилогдон, түүний өмнө хариуцан тайлагнах бөгөөд өдөр тутмын захиргааны асуудлыг хүрээнд ГУ-д хамаарна.

БҮЛЭГ 3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Бүх ХЭ нар нь компанийн ашгаас хүртэх болон компанийн засаглалд оролцох эрх эдэлнэ. Энэхүү эрх нь хууль, компанийн дүрэм болон холбогдох баримт бичгээр зохицуулагдсан байна.

3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал.

Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна. ХЭХ ээлжит болон ээлжит бус байна.

3.1.1. **Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажил.** Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч бүр ХЭ-дийн хуралд оролцох эрхтэй. Компанийн хувьд нийт хувьцаа эзэмшигчдийг ХЭ-ийн хуралд оролцож, хурлаас гарах шийдвэрт саналаа өгөх бололцоогоор хангахад анхаарна. Үүнийг хэрэгжүүлэхэд ХЭ-ийн хурлын зар болон хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичгүүд, хурлаас гарах шийдвэрийн төсөлд санал авах хуудас зэргийг багцалсан хурлын материалыг Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, тэдгээрээс бичгээр санал авах ажлыг ТУЗ-ийн ажлын албаар дамжуулан зохион байгуулна. ХЭХ-ийн материалыг ХЭ-дэд хүргүүлэх, хурлын удирдлага, зохион байгуулалт болон хурлын зарыг зарлах ажиллагааг ТУЗ-өөс баталсан тусгай журмаар тогтооно.

3.1.2. **Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт.** ХЭХ зохион байгуулалттай холбоотой зардлыг компани хариуцах бөгөөд хувьцаа эзэмшигчид ямар нэгэн хүндрэл бэрхшээлгүй хялбар аргаар, бага зардал гарган оролцохоор зохион байгуулна. Хурлын хэлэлцэх асуудлаар үнэн зөв, бүрэн мэдээлэлд тулгуурлан хурлаас гарах шийдвэрт санал өгөх боломжоор хангасан байхыг эрмэлзэнэ. Мөн ХЭХ-д биеэр оролцох боломжгүй тохиолдолд өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох, эсхүл санал авах хуудсаар саналаа өгөх замаар хуралд оролцож болно. Хурал хуралдуулах газрыг сонгохдоо биеэр ирж оролцоход хамгийн хялбар, нийтээр мэдэх байршлыг сонгоно. ХЭХ-д асуулт, тодруулгад хариулт өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон Хараат бус аудитын

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

байгууллага оролцоно. Хурал даргалагч нь хуралд оролцогчдод үг хэлэх бололцоогоор бүрэн хангах ба хурал хуралдуулах журмыг чанд сахина. ХЭХ-ийг санал хураалтыг саналын хуудсаар явуулна. ХЭХ-ийн ирцийг тодорхойлох, хурлын санал хураалтын дүнг гаргаж хурлын даргад мэдээлэх үүрэг бүхий тооллогын комиссыг ТУЗ нь компаниас томилох бөгөөд, эсхүл хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон ажиллуулж болно. Тооллогын комиссын гишүүд нь тухайн хурлын хэлэлцэж буй асуудлаар сонирхлын зөрчилгүй хүн байна. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэртэй уялдуулан компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэдээлэл технологийн шийдэл ашиглан зайнаас зохион байгуулж болно.

3.1.3. **Хувьцаа эзэмшигчдийн хурлын үр дүнг мэдээлэх.** Санал хураалтын дүн болон хурлаас гарсан шийдвэрийг хурлын төгсгөлд уншиж танилцуулахаас гадна компанийн вэб сайтад олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна. Харин хурлын дараа хурал хуралдуулсан талаарх тайланг бэлтгэж зохицуулагч байгууллага болон хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд ТУЗАА хариуцна.

3.2. **Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах**

Компани нь ХЭ-ийг санал, гомдлыг хүлээн авч бүртгэх болон Хувьцаа эзэмшигчидтэй холбоотой үүссэн маргааныг зохицуулах тогтолцоотой байна. Энэ ажлыг ТУЗАА хариуцах бөгөөд үүссэн асуудлаас хамааран Гүйцэтгэх удирдлагатай хамтран хариуцан ажиллаж болно.

3.2.1. **Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл.**

ХЭ-ийн бүртгэлийг “ҮЦТХТ” ХХК-иар гэрээний үндсэн дээр хөтлүүлдэг. Компани хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг мэргэжлийн байгууллагаар хөтлүүлэх нь хувьцааны бүртгэлийн найдвартай, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангахад оршино.

3.3. **Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх ажил, гүйлгээ.**

Компани нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцлээс аль болох зайлсхийх ба хэлцэл хийх тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлахаас гадна энэхүү хэлцлийн тухай мэдээллийг хуульд заасны дагуу нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчилтэй буюу хамаарал бүхий этгээдтэй хийсэн хэлцлийн хамгаалалт болгож компани нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, өөрчлөгдсөн бол жагсаалтад тухай бүр өөрчлөлтийг оруулж, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ. Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх тусгай журамтай байна. Энэ журмыг ТУЗ-ийн тогтоолоор баталж, олон нийтэд ил тод, нээлттэй хэлбэрээр байна.

3.4. **Ногдол ашгийн бодлого**

Компани нь ТУЗ-өөс баталсан ногдол ашгийн бодлоготой байх ба тэрхүү бодлого нь олон нийтэд ил тод, нээлттэй байна. Ногдол ашгийн бодлого нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- Ногдол ашиг хуваарилах нөхцөл, хугацаа нь тодорхой байх;
- Хувьцаа эзэмшигч өөрт ногдох ногдол ашгийн хэмжээг тооцоолох аргачлалыг ойлгомжтой тусгагдсан байх;
- Ногдол ашгийг бүрэн, цаг хугацаанд нь төлөх бөгөөд горим алдагдах тохиолдолд алданги төлдөг байх талаар тусгагдсан байх.

БҮЛЭГ 4. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, төрийн эрх бүхий байгууллагад компанийн тухай үнэн зөв мэдээллээр цаг тухайд нь хангаж байх нь Компанийн засаглалын гол зарчим юм

4.1. Компанийн мэдээллийн бодлого ба практик ажиллагаа

Компани нь удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, санхүүгийн байдал, үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хяналтын болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, эцсийн өмчлөгчийн талаарх материаллаг мэдээллүүдийг хувьцаа эзэмшигч, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээнэ. ТУЗ нь дээрх мэдээллийг ил тод, нээлттэй байх орчинг бүрдүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана. Компани нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргаж байхын зэрэгцээ улирлын тойм мэдээ, томоохон үйл явдал зэргийг тухай бүр мэдээнэ. Компани нь нийтэд нээлттэй байхаас бусад нууц болон маш нууц мэдээлэлд хамаарах дотоод мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын стандартын хүрээнд батлагдсан дотоод дүрэм журмаар хамгаална.

4.2. Санхүүгийн тайлан

Компани нь Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу санхүүгийн жилийн тайланг хараат бус аудитын дүгнэлтийн хамт нийтэд ил тод, нээлттэй байна. Компани нь өөрийн охин компанийн санхүүгийн тайланг нэгтгэн нэгдсэн тайлан гаргана.

4.3. Дотоод аудит ба хяналт

4.3.1. Дотоод аудит

Компани нь өөрийн дотоод аудитын нэгжтэй байх бөгөөд компанийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн дотоод аудитаар дамжуулан хэрэгжүүлнэ. Дотоод аудитын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагаа хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт санхүүгийн бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-өөс баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

4.4. Хөндлөнгийн аудит

Компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ажиллуулна. Хөндлөнгийн аудит нь олон нийтэд танигдсан хараат бус аудитын байгууллага байна. Хараат бус гэдэгт тухайн байгууллага нь аудитын үйлчилгээ үзүүлж буй компанитай бизнесийн харилцаа холбоо байхгүй байх, аудитын ажлыг баримталбал зохих олон улсын стандартын дагуу мэргэжлийн түвшинд хийж чаддаг гэдгээ олон жилийн хугацаанд нийтэд харуулж чадсан байхыг хэлнэ. Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх САХ зохион байгуулж ТУЗ-өөс сонгоно.

4.5. Компанийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, мэдээлэх

Компани нь саналын эрхтэй хувьцааны тав ба түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгчийг тодорхойлно.

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

Хавсралт №1. Товчилсон үгийн тайлал

Компанийн засаглалын нийтлэг товчилсон үгийн тайлал

ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл	Board of directors
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал	Shareholders' meeting
ХЭЭХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Regular shareholders' meeting
ХЭЭБХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал	Irregular shareholders' meeting
САХ	Санхүү, аудитын хороо	Finance, audit committee
ЭУХ	Эрсдэлийн удирдлагын хороо	Risk management committee
НДШУХ	Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо	Nomination and remuneration committee
ОУ	Олон улс	International
КтХ	Компанийн тухай хууль	Company law of Mongolia
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо	Financial regulatory commission
МХБ	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК	“Mongolian stock exchange” JSC
ХЭ	Хувьцаа эзэмшигч	Shareholder
КЗ	Компанийн засаглал	Corporate governance
ТЗК	Тусгай зориулалттай компани	Special proposed company
ГУ	Гүйцэтгэх удирдлага	Executive management
ГУЗ	Гүйцэтгэх удирдлагын зөвлөл	Executive management council
ТУЗАА	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба	Board secretariat
ТУЗ-НБД	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Board secretary
ХБГ	Хараат бус гишүүн	Independent director/member
ХО	Хөрөнгө оруулагч	Investor
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	Mongolian Central Securities Depository
СЗЭХ	Сонирхлын зөрчилтэй этгээд, түүнтэй байгуулах хэлцэл	Transaction with conflicted interest party
НСЭХ	Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй байгуулах хэлцэл	Transaction with related party
ИХХ	Их хэмжээний хэлцэл	Major transaction
ҮЦЗЗтХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Law on securities market in Mongolia

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодекс	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

ХБҮЦгХ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль	Law on asset backed securities in Mongolia

Хавсралт №2. Нэр томъёоны тайлбар

Компанийн засаглалын нийтлэг нэр томъёоны тайлбар

МИК Групп компани		MIK Group company
Хууль тогтоомж	Монгол Улсын хууль, эрх бүхий байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөгдөх шинжтэй эрх зүйн хэм хэмжээний актын цогц	Legislation
Олон улсын сайн туршлага	Олон улсын нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлага	International good practice
Үндэсний сайн туршлага	Дотоодын нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн туршлага	National good practice
Зөвшөөрөгдсөн цахим шуудан	Компанийн холбогдох дотоод журмын дагуу үүсгэсэн @mik.board.mn өргөтгөлтэй цахим шуудан	Approved email
Бүрэн эрхийн хугацаа	Компанийн дүрэм болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр тогтоосон ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаа	Term of office
ТУЗ-ийн гишүүн	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гэж тусгайлан зааснаас бусад тохиолдолд ТУЗ-ийн дарга, гишүүн	Member of the board
Хурал	ХЭХ, ТУЗ, түүний дэргэдэх хороодын хурал	Meeting
Горимын санал	Шийдвэр гаргагчаас зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаарх санал	
Зарчмын зөрүүтэй санал	Шийдвэрийн төсөлд агуулгын өөрчлөлт оруулахтай холбоотой санал	Controversial suggestion
Найруулгын санал	Шийдвэрийн төслийн зорилго, агуулга, зарчмын алдагдуулахгүйгээр зүйл, хэсэг, заалтыг уялдуулан дэс дараалал, бүтцэд өөрчлөлт оруулах, нэр томъёог жигдлэх, үг, өгүүлэх, хэллэгийг монгол хэлний дүрэмд нийцүүлэхтэй холбоотой санал	Drafting suggestion
Хороо	ТУЗ-өөс байгуулсан байнгын, түр хороо	Committee/Sub committee
Хуралд оролцогч	ХЭХ, ТУЗ, түүний дэргэдэх хороодын хуралд оролцож буй ТУЗ-ийн ажлын албаны ажилтан, асуудал танилцуулах ГУ, холбогдох нэгжийн удирдлага, тэдгээрийн орлон гүйцэтгэгч нар, гадны зочид, төлөөлөгчид	Participant in meeting

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Компанийн засаглалын кодексе	Хувилбар 1.0	Баталсан огноо: 2021/03/19

Хараат бус гишүүн	Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангаж компанийн нийт хувьцаа эзэмшигчдийг төлөөлж сонгогдсон ТУЗ-ийн гишүүн	Independent director/member
Ердийн гишүүн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан шаардлагыг хангаж компанийн хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн, түүнийг төлөөлөхөөр сонгогдсон ТУЗ-ийн гишүүн	Dependent/Nominee director/member
Кумулятив арга	Эзэмшиж байгаа хувьцааны тоог хуваан санал өгөх хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнийг сонгох арга	Cumulative method
Ердийн арга	Хамгийн олон санал авснаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох арга	General method
Ердийн олонх	100-ны 50 хувь буюу 1/2	Majority
Дийлэнх олонх	100-ны 66.67 хувь буюу 2/3	Absolute majority
Хурлын тов	Хурал хуралдах хугацаа, байршил	Date of meeting
Дотоод мэдээлэл	Дотоод мэдээлэл гэдэг нь нийтийн хүртээл болоогүй тодорхой үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх санхүүгийн мэдээлэл	Insider information

